



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/699

Мөрөн сум

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх
зарим арга хэмжээг хэрэгжүүлэх тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйл 66.1, 74 дүгээр зүйлийн 74.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 86 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тухайн нутаг дэвсгэрийнхээ нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд суурилуулсан болон аж ахуй нэгж, байгууллагын гадна орчны теле камерыг нэгдсэн сүлжээнд холбох, камерын хяналтад ороогүй бүсийг шинээр камержуулах ажлыг зохион байгуулах, шаардагдах зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу 2025 оны төсөвт тусган батлуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Тухайн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, түргэн шуурхай илрүүлэх ажлын хүрээнд цагдаагийн албаны хүчийг нэмэгдүүлэх зорилгоор сум тус бүрд нэг олон нийтийн цагдаагийн ажилтан ажиллуулахыг аймгийн Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Д.Мөнхжаргал)-т, албан хаагчийн цалин хөлс, хувцас хэрэглээний зардлыг 2025 оны төсөвт тусган шийдвэрлүүлэхийг сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Г.Гандэлгэр)-т даалгасугай.


ОРЛОГЧ



Ц.ГАНСҮХ

6712012177

Аймгийн Засаг даргын 2024 оны
12 дугаар сарын 24-ний өдрийн А/699
дүгээр захирамжийн хавсралт



ОЛОН НИЙТИЙН НЭГ ЦАГДААГИЙН ЦАЛИН ХӨЛС,
ХОЛБОГДОХ БУСАД ЗАРДЛЫН ТООЦОО

2024 оны 12 дугаар сарын 16-ны өдөр

Мөрөн сум

№	Нэг олон нийтийн цагдаад шаардагдах зардал	Нэг сарын цалин	Жилийн зардал	Нийт
1	Цалин	1.200.000 төгрөг	14.400.000 төгрөг	14.400.000 төгрөг
2	Хувцас, хэрэгсэл	-	1.355.931 төгрөг	1.355.931 төгрөг
3	Дүн	1.200.000 төгрөг	15.755.931 төгрөг	15.755.931 төгрөг

ОЛОН НИЙТИЙН ЦАГДААГИЙН ХУВЦАС, ХЭРЭГСЛИЙН ТӨРӨЛ, ҮНЭЛГЭЭ

№	Нэршил	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ
1	Ноосон малгай	1	11.000
2	Саравчтай малгай	1	30230
3	Өдөр тутмын хүрэм, өмд	1	178.907
4	Өвлийн хиймэл захтай хүрэм, өмд	1	291.949
5	Борооны цув	1	123.200
6	Хантааз	1	72.000
7	Цамц /богино ханцуйтай /	1	55.175
8	Цамц /урт ханцуйтай /	1	46.000
9	Зангиа	1	6.350
10	Өвлийн гутал	1	270.000
11	Богино түрүүтэй гутал	1	154.000
12	Тоногтой бүс	1	113.300
13	Ханцуйн бэлгэдэл, тэмдэг	1	3820
14	Энгэрийн камер	1	485.000
	Нийт	14	1.355.931